

Хүсээгүй магтаал-хүсээгүй үйлдэл

МУИС-ийн Сэтгүүлчийн 3-р түвшний оюутан Ж. Даваадулам

Кейс-1

“Би тэр өдрийг мартдаггүй юм. Түүний өмссөн хувцас, нүдээрээ ирмэж, жуумалзан инээсэн төрх...

2019 оны наймдугаар сар. Хичээлийн шинэ жил дөхөж, их хотод чимээ шуугиан, хөдөлгөөн, түгжрэл ихсэж байсан үе. Ажлаа тараад гэр лүүгээ харихаар оройн 20 цаг орчмын үед 4:53 ЯАРМАГ-МУБИС чиглэлийн автобусанд амжиж суулаа. Хамгийн хойно очоод зогсоход хаалганы хажууд зогсож байсан 30 гаран насны залуу миний чанх ард ирээд зогссон. Нэг л таагүй мэдрэмж. Намайг араас шахаж зогсож байгаад чихэнд сайхан бүсгүй байна шүү гэж хэлчхээд, бэлэг эрхтнээ өгзгөнд хүргэв. Би айж балмагдсандаа таг дугуй зогсчихсон. Хүмүүсээс тусламж эрэх гэсэн ч амнаас үг гараагүй. Хөл чичирч, арай хийн ганц хоёр алхам түүнээс холдож зогслоо. Хурдхан бууж, зугтмаар болж байсан мэдрэмжийг одоо ч тод санадаг. Автобус дараагийн буудал дээр зогсоход тэр над руу эргэж хараад нүдээрээ ирмэж, жуумалзчихаад буучихсан. Тэр үед надад мэдрэгдсэн мэдрэмжийг мартдаггүй ч чухам яаж автобусаас бууж гэртээ харьснаа санадаггүй юм” хэмээн 23 настай Э ярилаа.

Бэлгийн дарамтын талаарх яриа хөндөгддөг ч бодитой шийдэлд хүрч чадахгүй байсаар нийгэмд бугшчихжээ. Нөгөө талаас бэлгийн дарамтад өртөгсөд нь хүлцэн тэвчиж, бусдад мэдэгдэхээс ичиж, чимээгүй өнгөрөөсөөр хэн нэгний гаж дур хүслийг хангах, цаашлаад бие махбодь сэтгэл зүйгээрээ хохирон үлдэж байгаа нь харамсалтай. Тухайн эмэгтэйн өмссөн хувцас, биеэ авч явж буй байдал, өөрийгөө хамгаалах чадваргүй байх зэрэг нь хүчирхийлэл үйлдэгчдийн том бай болдог мэтээр хохирогчийг буруутгаж, үйлдэгчийг өөгшүүлэх нь ч бий. Угтаа бол хүсээгүй байхад нь магтсан үг ч бэлгийн дарамтын нэг хэлбэр. Магтаал бол тухайн хүнийг урамшуулж, баярлуулж байх урмын үг. Гэтэл хүсээгүй байхад нь гоё, сайхан үгсийг зөөлөн шивнэж, сэтгэл санааг нь түгшээж байна гэдэг магтаалын хэлбэр яавч биш. Хуулиндаа ч бий. Тодруулбал,

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7:

“Бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр илэрхийлэх, мөн бэлгийн сэдлийн улмаас сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхгүйг бэлгийн дарамт гэнэ” хэмээн тодорхойлсон.

Олон нийтийн газар, ажил, сургууль, нийтийн тээвэр гээд хаана ч, ямар ч хэлбэрээр үйлдэгдэх бэлгийн дарамтад аль ч насны охид, бүсгүйчүүд өртөх эрсдэлтэй. Эрх баригчдаас хүртэл энэ хэрэгт холбогдсон тохиолдол бий. Тэгэхээр бэлгийн дарамт үйлдэгчийг гаднаас нь хараад мэдэх боломжгүй аж. Хэн ч, хаана ч охид, бүсгүйчүүдийг хүсээгүй байхад нь магтаж, хүсээгүй үйлдлийг нь хийж сэтгэл зүй болоод бие махбодоор хохироож болдог нийгэмд амьдарч байна.

Кейс-2

“Наймдугаар ангийн өвөл тохиолдож байв. Хичээлээ тараад тав, зургаан цагийн үед гэр лүүгээ явдаг чиглэлийн автобусанд суугаад явж байлаа. Автобусны эцсийн буудал дөхөж, хүмүүс бага багаар цөөрсөөр, хажууд нэг ах ирж суув. Суугаад шууд л миний гуянаас базсан. Яг тийм зүйл тохиолдох үед юу хийхээ мэддэггүй юм байна лээ. Ямар ч гэсэн маш их айж, ичиж байсан юм. Удсан ч үгүй дахиад л гар нь дээшилж хөхөнд хүрэх нь тэр. Надад үнэхээр ичмээр бас аймар санагдаж “болиоч ээ” гэж зөөлөн амандаа бувтначхаад тэр дороо босож явсан. Айгаад эргэж харалгүй зогссоор нэг буудлын наана бууж байлаа. Өвөл байсан болохоор их хүйтэн бас харанхуй. Гэр лүүгээ алхаж байхдаа байн, байн эргэж харан олон хүн бараадсаар харьсан. Тэр явдлаас хойш автобусанд ч гэлтгүй эрэгтэй хүнтэй ойр зогсоход, олон эрэгтэй хүнтэй газар таагүй мэдрэмж төрүүлдэг болчихсон. Энэ талаар олон хүнд ярьж байгаагүй ээ. Маш их ичдэг.”

хэмээн 21 настай Х ярив.

Хэдийгээр тодорхой хэмжээний цаг хугацаа өнгөрсөн ч тэрхүү үйл явдлаа огт мартдаггүй, дахиад тийм зүйл тохиолдох вий гэсэн айдас үргэлж байдаг хэмээн эх сурвалж хэлсэн юм. Үүнийг сэтгэл зүйч Я.Батхүүгээс тодруулахад “Дөрвөн эмэгтэй тутмын нэг нь амьдралдаа дор хаяж нэг удаа бэлгийн дарамтад өртсөн байдаг. Бэлгийн дарамтад өртсөнөөр өөртөө итгэх байдалд сөргөөр нөлөөлөх ба эрэгтэй хүнд итгэх итгэл найдварыг үгүй болгодог. Мөн таагүй зүйл мэдэрснийхээ дараа хоолонд дургүй болох, хар дарж зүүдлэх, айх, түгших, тэрхүү үйл явдлаа дахин дахин бодож шаналдаг”.

Өмнө хэлсэнчлэн бэлгийн дарамт үйлдэгчийг хараад таних аргагүй байдаг. Харахад энгийн хүн боловч гаж хүсэлтэй, тэр хүслээ дураараа гаргадаг үйлдэгчийн сэтгэл зүйн талаар сэтгэл зүйч Я.Батхүү тайлбарлахдаа “Үйлдэгчдийн дийлэнх нь санаатайгаар үйлддэг ба өөрийн дурандаа үйлдэж буй тэрхүү үйлдэл нь нэгэнтээ эмгэг болчихсон байх нь бий. Ихэвчлэн эрэгтэй хүн бэлгийн дарамт үйлддэг нь тестостероны ялгаралтай чухал хамааралтай. Өөрөөр хэлбэл бэлгийн дарамт үйлдэж түүнээсээ таашаал авах хандлагатай болчихсон байдаг. Тархи ямар нэг таатай мэдрэмжид дуртай тул тэрхүү мэдрэмжийг нь дахин нэхнэ. Өөрийн үзэл бодолгүй, зорилгогүй, боловсролгүй нэг үгээр бол төлөвшөөгүй хүн байгалийн зөнгөөрөө тархи юу хүснэ түүнийгээ шууд л үйлддэг” гэлээ.

Ямар ч төрлийн хүчирхийлэл бай бид нийгэм даяараа үүнийг үл тэвчих соёлд суралцах ёстой. Наад зах нь олон нийтийн зүгээс хэн нэгнийг бэлгийн дарамтад өртөж буйг харсан бол, мэддэг бол холбогдох байгууллагад ханддаг байх хэрэгцээ шаардлага үүсэж байгаа юм. Тэгвэл энэ талаар хууль эрх зүйн зохицуулалт ямар байдаг талаар цагдаагийн дэслэгч Ж.Лхагвадоржоос тодруулахад “Нийтийн тээвэр, олон нийтийн газар эмэгтэй хүнийг хүчиндэх сэдэл зорилготой үйлдлийн шинж тэмдэг илэрсэн байх юм бол хүчиндэх, дээрэмдэх хэргээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин эмэгтэй хүний биед нь зөвшөөрөлгүй хүрэх үйлдэл нь хуульд тусгагдаагүй байдаг. Хэрвээ хэн нэгэн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй нөхцөл байдалд байгаа бол цагдаагийн байгууллагын 102, 107, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх хүүхэд хамгааллын 108 утсанд мэдээлэх хэрэгтэй” хэмээв.

Олон нийтийн зүгээс бэлгийн дарамт үйлдэгчийг харсан ч хараагүй мэт өнгөрүүлсээр тэдэнд “Ингэж болдог юм байна”, “Ингэлээ гээд яах ч үгүй” гэсэн тогтсон хандлага бий болж, бэлгийн дарамт цаашлаад бэлгийн хүчирхийлэл нь нийгмийн чимээгүй тахал болон даамжрах хандлагатай байна.

Олон улсад олон нийтийн газар, нийтийн тээвэр дэх бэлгийн дарамтын талаар хийгдсэн судалгаа, баримтыг судалж үзэв. Тодруулбал, Оксфамас явуулсан судалгаагаар олон нийтийн газар эмэгтэйчүүд, охид бэлгийн дарамтад өртдөг. Энэ нь эрчүүдийн хэвийн зан авир, өдөр тутмын үзэгдэл агаад тухайн эмэгтэйн хувцаслалт зэрэг хохирогчийн буруу гэж үзэх хандлагатай байдаг байна. Нийтийн тээвэрт бэлгийн дарамтад өртөх нь тэдний хэдийн үзэгдэл мэт тогтсон ойлголтоос шууд хамаарч энэхүү дарамтыг өдөөх нэг хүчин зүйл болдог ажээ. Шри Ланка дахь эмэгтэйчүүд, охидын 90 хувь нь амьдралынхаа туршид дор хаяж нэг удаа автобус,

галт тэрэг бусад газар бэлгийн дарамтад өртөж, талаас илүү хувь нь хүчирхийлэлд байнга өртөж байсан гэж НҮБ-аас гаргасан судалгаагаар нотолсон.

Монголд нийтийн тээвэр дэх бэлгийн дарамтын талаар хийгдсэн судалгаа байдаггүй бөгөөд энэхүү сурвалжилгынхаа хүрээнд хийсэн судалгаагаа хүргэж байна.

Судалгааг төрийн өмчийн томоохон их дээд сургуулиуд болох МУИС, МУБИС, СЭЗИС, АШУИС, ШУТИС, ХААИС мөн бусад төрийн болон хувийн өмчийн сургуулиудын 110 оюутнаас асуулга буюу анкетын аргаар авсан. Судалгаанд оролцогчдын 57,3 хувь нь бэлгийн дарамтад ямар нэгэн байдлаар өртсөн ба тэдгээр охидын 53 хувь нь сэтгэлзүйд хүндээр нөлөөлсөн хэмээн хариулжээ. Бэлгийн дарамт бол хүлцэн тэвчиж, чимээгүй өнгөрөөх асуудал биш гэдгийг судалгааны үр дүн харууллаа.

Олон улсын түвшинд болон Монгол улсын хувьд бэлгийн дарамтын талаарх асуудлыг хөндөж, хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлага үүсэж байгаа гэдгийг дурдах нь зүйтэй.